

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код : 45.020

Хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалт. 3-р хэсэг: Татах хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтад тавих шаардлага	MNS 6630-3 : 2023
Rolling stock Part 3: Identification marking for motor tractive stock.	MNS 6630-3 : 2016-ийн оронд

Стандартчиллын үндэсний зөвлөлийн оныдүгээр сарын-ний өдрийн
..... дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандарт оны дүгээр сарын-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэ стандартын шаардлагыг заавал мөрдөнө.

1 Хамрах хүрээ

Төмөр замын татах хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалт нь Олон улсын төмөр замын тээврийн гэрээ, эрх зүйн хэм хэмжээний баримт бичиг, Төмөр замын тээврийн тухай хууль болон энэхүү стандартын шаардлага дагуу төмөр замын тээврийн байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох, нэгдсэн бүртгэл мэдээллийн өгөгдлийн баазыг бүрдүүлэн ажиллах, мэдээллийн системийн журмыг мөрдөхөд үндэслэх баримт бичиг болох мөн бүртгэгдсэн хөдлөх бүрэлдэхүүний техникийн магадлагаа болно.

Энэхүү стандарт нь Монгол Улсын төмөр замын тээврийн байгууллагууд болох суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч болон татах хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгч нарын хоорондын харилцааг болон үйл ажиллагааг үндсэн нэг хэл дээр зохицуулан, зохион байгуулах нөхцлийг хангахад хамаарагдана.

2 Нэр томъёо ба тодорхойлолт

Энэхүү стандартад “Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний нэр томъёо, тодорхойлолт” MNS 6387-3:2013 стандартын нэр томъёо, тодорхойлолтыг ашигласан болно.

2.1 Татах хөдлөх бүрэлдэхүүний нэгжийн өмчлөгч

Хөдлөх бүрэлдэхүүний нэгжийг аюулгүй ашиглах, түүнийг техникийн хувьд эвдрэл гэмтэлгүй бүрэн ажиллагаатай байлгах хариуцлагыг хүлээсэн, түүнийг захиран зарцуулах эрх бүхий этгээд

MNS 6630-3 : 2016

3 Норматив эшлэл

Энэхүү стандартад дараах эш татсан стандарт, зөвлөмжийн баримт бичгүүдийг хэрэглэсэн. Он заасан эшлэлийн хувьд зөвхөн эш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Он заагаагүй эшлэлийн хувьд тухайн стандарт, зөвлөмжийн хамгийн сүүлийн хэвлэлийг хэрэглэнэ. Үүнд:

3.1 MNS 6387-3:2013 “Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний нэр томъёо, тодорхойлолт”;

3.2 MNS 5833:2014 “Төмөр замд барилга байгууламжийн ойртолтын болон хөдлөх бүрэлдэхүүний овор хэмжээ”;

3.3 MNS EN15273-2:2016 “Төмөр замын хэрэглээ. 2-р хэсэг. Овор. Хөдлөх бүрэлдэхүүний овор” ;

3.4 MNS EN 15877-1,2:2016, Төмөр замын ашиглалт–Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн дээр тэмдэг, тэмдэглэгээ тавих;

3.5 MNS 6039: 2009 “Илчит тэрэг. Техникийн ерөнхий шаардлага”;

3.6 MNS 6630-1:2016 ” Хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалт.1-р хэсэг. Төмөр замын зорчигчийн вагоны дугаарлалтад тавих шаардлага”,

3.7 MNS 6630-2:2016 ” Хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалт.2-р хэсэг. Төмөр замын ачааны вагоны дугаарлалтад тавих шаардлага”,

3.8 MNS 6630-3:2016 ” Хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалт.3-р хэсэг. Татах хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтад тавих шаардлага”,

3.9 MNS 6630-4:2016 ”Хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалт. 4-р хэсэг. Төмөр замын, замын тусгай хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтад тавих шаардлага”,

3.10 MNS 6631-14:2016 Төмөр замын тээврийн харилцаанд хэрэглэгдэх Улс ороны нэгдсэн тоон кодчилал;

3.11 O+P 913 “Хөдлөх бүрэлдэхүүний хяналтын тоог тодорхойлох журам”.

4 Татах хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтад тавих шаардалага

4.1 Татах хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалт нь Олон улсын төмөр замын хамтын ажиллагааны байгууллагаас батлаж өгсөн хүчин төгөлдөр мөрдөж буй заавар журам, болон энэхүү стандартын шаардлагыг хангасан байна.

4.2 Олон улсын тээвэрт ашиглаж буй татах хөдлөх бүрэлдэхүүн төлөвлөгөөт үзлэг, засварт орох мөн шинэ систем, техник, тоног төхөөрөмжөөр тоноглогсон бол энэхүү стандартын шаардлагын дагуу дугаарлалт, тэмдэг, тэмдэглэгээг хийсэн байна.

4.3 Хэрэв Олон улсын төмөр замын хамтын ажиллагааны байгууллагаас батлаж өгсөн хүчин төгөлдөр мөрдөж буй энэхүү стандартын норматив эшлэлд заасан баримт бичгийн нөхцөл, шаардлага ,зүйл заалт,

харилцан зохицох чадварын тодорхойлолтод өөрчлөлт орвол энэхүү стандартыг дахин хянан өөрчлөх болно.

4.4 Төмөр замын татах хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалт нь Олон улсын төмөр замын хамтын ажиллагааны байгууллагаас батлаж өгсөн 12 орон бүхий тоотой дугаарлалтаар зохицуулна.

4.5 Олон улсын тээвэрлэлтэд буюу галт тэрэг болон хөдлөх бүрэлдэхүүнийг хөрш зэргэлдээ улсын төмөр замруу гаргаж шилжүүлэн өгөх, их засварт явах зэрэгт татах хөдлөх бүрэлдэхүүн нь Төмөр замын хамтын ажиллагааны байгууллага, Олон улсын төмөр замын холбоо нарын хамтарсан “Кодчилол болон мэдээлэл зүйн” ажлын хэсгээс боловсруулан баталсан баримт бичгийн дагуу дугаарлалтын тэмдэг, тэмдэглэгээ бичиглэлийг хийж, явуулах болно.

4.6 Олон улсын Төмөр замын хамтын ажиллагааны байгууллагын гэшүүн улсын татах хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалт ижил бүтэцтэйгээр тодорхойлж, тухайн бүртгэгдсэн улсын нутаг дэвсгэр дээр, мөн хилийн өртөөдөд ашиглагдана.

4.7 12 оронтой тоон дугаарлалттай татах хөдлөх бүрэлдэхүүний нь дараах бүтэц, агуулгатай байна. Үүнд:

а) Тухайн төмөр замын бүсийн кодыг эхний 2 орон тодорхойлно. (Эхний хоёр орон)

б) Татах хөдлөх бүрэлдэхүүнийг бүртгэсэн улсын кодыг дараагийн 2 орон тодорхойлно. (Дараагийн хоёр орон)


в) Татах хөдлөх бүрэлдэхүүний өмчлөлийн код нь 5 болон 6-р ороны тоо нь байна. (3 дахь хоёр орон)

г) Татах хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтын 7 ороны тоо нь 3-р хүснэгтэд заасны дагуу татах хөдлөх бүрэлдэхүүний төрөл, ангиллыг харуулсан кодоор олгосон дугаар байна.

д) Татах хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтын 8,9,10,11 ороны тоо нь татах хөдлөх бүрэлдэхүүний үйлдвэрлэгчээс олгосон дугаар байхаас гадна төрөл, зориулалт, голын тоо, техникийн үндсэн болон нэмэлт үзүүлэлтийг тодорхойлсон дугаар байна.

г) Татах хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтын сүүлийн тоо хяналтын тоо байна.

4.8 Хоёр системийн хооронд хөрвөх чадвартай байх тоон код буюу бүсийн код Татах хөдлөх бүрэлдэхүүний 12 оронтой дугаарлалтын эхний хоёр тоо хөрвөх чадвартай, тухайн төмөр замын бүсийн код байна.



1-р схем - Татах хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтын систем

4.9 Татах хөдлөх бүрэлдэхүүнийг бүртгэсэн улсын кодыг тодорхойлох

Татах хөдлөх бүрэлдэхүүнийг бүртгэсэн улсыг Олон улсын Төмөр замын хамтын ажиллагааны байгууллагаас баталсан 920-14 аргачлал дагуу кодчилно.

Татах хөдлөх бүрэлдэхүүний 12 оронтой дугаарлалтын 3,4-р ороны тоо нь Монгол Улсын төмөр замын байгууллагуудын код болох “31” гэсэн тоо байна. Энэ бүх хөдлөх бүрэлдэхүүнд ижил бичигдэнэ.

ЖИШЭЭ НЬ: 31-Татах хөдлөх бүрэлдэхүүнийг бүртгэсэн улсын код.

4.10 Татах хөдлөх бүрэлдэхүүний өмчлөгч байгууллагын код нь 5,6-р ороны тоо байх ба дараахь байдлаар бичиж тэмдэглэсэн байна.

ЖИШЭЭ НЬ: 01-“Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн Татах хөдлөх бүрэлдэхүүний өмчлөгчийн код

4.11 Татах хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгч бүр кодтой байх ба өмчлөгч өөрчлөгдсөн тохиолдолд код, дугаар, лого, тэмдэг тэмдэглэгээ өөрчлөгдөж болно.




4.12 Олон улсын Төмөр замын хамтын ажиллагааны байгууллагын гэшүүн улсын бүртгэлийн дугаар, тоон болон үсгэн тэмдэглэгээг дараах хүснэгтэд үзүүлэв.

1-р хүснэгт-Олон Улсын төмөр замын код

Төмөр замын Улсууд			Үйлдвэрлэлийн нэр	Монгол Улсын төмөр замуудын тэмдэглэгээ, лого
Болгар	BG	52	БДЖ,ЕАД	 <p>Монголын төмөр замууд- "MGL"</p>
Унгар	MAB	55	MAB	
Гүрж	GR	28	ГР	
БНХАУ	RC	33	КЖД	
Казахстан	KZ	27	КЗХ	
МОНГОЛ	MGL	31	МТЗ	
Латвия	LV	25	ЛДЗ	
Литов	LT	24	ЛГ	
Молдов	MD	23	ЧФМ	
Польша	PL	51	РКР	
Россия	RUS	20	РЖД	
Румын	RO	53	ЧФР	

4.13 Олон улсын Төмөр замын хамтын ажиллагааны байгууллагын гэшүүн улсад бүртгэгдсэн татах хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгчийн бүртгэлийн дугаар, тоон болон үсгэн тэмдэглэгээг дараах хүснэгтэд үзүүлэв.

2-р хүснэгт - Татах хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгч байгууллагын код

Д/д	Төмөр замын ачааны вагоны өмчлөгчийн нэр	Төмөр замын байгууллагын лого	Төмөр замын ачааны вагон өмчлөгчийн код	Төмөр замын ачааны вагоны өмчлөгчийн тэмдэглэгээ
1	"Улаанбаатар төмөр зам" ХНН		01	УБТЗ ХНН
2	"Монголын төмөр зам" ТӨХК		02	МТЗ ТӨХК
3	"Болд төмөр Ерөө гол" ХХК		03	БТЕГ ХХК
4	Хөтөлийн "Цемент шохой" ТӨХК		04	Цемент шохой ТӨХК
5	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	 "ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ХХК	06	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ
6	"Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ТӨХК		07	ЭДЦС ТӨХК

7	“Монголын алт МАК” ХХК		09	МАК ХХК
8	“Багануур” ХК		10	Багануур ХК
9	“Мөнгөн хөдөлгүүр” ХХК		11	Мөнгөн хөдөлгүүр ХХК
10	“Шарын гол” ХХК		12	Шарын гол ХХК
11	“Монголрос цветмет” ТӨҮГ		13	Монголросцветмет ТӨҮГ
12	“Дулааны цахилгаан станц- 4” ТӨХК		15	ДЦС-4 ТӨХК
13	“Тавантолгой төмөр зам” ХХК		16	ТТЗ ХХК
14	“Монцемент билдинг” ХХК		19	Монцемент билдинг ХХК
15	“Монголиантранс ложистик” ХХК		22	Монголиантранс ложистик ХХК
16	п...	п...	35	
17			п...	

4.14 Татах хөдлөх бүрэлдэхүүний 12 оронтой дугаарлалтын системийн сүүлийн 7-11 ороны тоо нь 4.7-ийн “Д” заасан үзүүлэлтийг тодорхойлж, сүүлийн тоо хяналтын тоо байна.

4.15 Татах хөдлөх бүрэлдэхүүний төрөл, ангиллын кодыг баталсан байх ба дараах хүснэгтэд үзүүлэв.

3-р хүснэгт - Татах хөдлөх бүрэлдэхүүний төрөл, ангиллын код буюу дугаарлалтын 7 дахь ороны тоон утга

Код	Татах хөдлөх бүрэлдэхүүний нэгжийн төрөл, ангилал
1	Цахилгаан зүтгүүр
2	Илчит тэрэг
3	цахилгаан моторт вагон /өндөр хурдны, моторт вагон болох хөдлөх бүрэлдэхүүний засварын вагон/
4	цахилгаан моторт вагон /өндөр хурдны, моторт вагон болох хөдлөх бүрэлдэхүүний засварын вагон/
5	Дизель вагон (моторт вагон буюу бүрэлдэхүүн дэхь засварын вагоны 2 дахь оронтой тоонд ашиглагддаг утгуудыг санал болгосон)
6	Тусгай чиргүүл
7	Бага хүчин чадалтай цахилгаан зүтгүүр
8	Бага хүчин чадалтай илчит тэрэг
9	Хөдлөх бүрэлдэхүүний засварын нэгж
0	Бусад

4.16 Дугаарлалтын 8,9,10,11-р орны 4-н тоог Татах хөдлөх бүрэлдэхүүнийг бүртгэсэн улсын төмөр замын байгууллагын дүрэм, журам болон энэхүү стандартад заасан шаардлагын дагуу тодорхойлон тогтоож ашиглана.

4.17 Татах хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтын цуврал тоон кодчиллын тусгай татах хөдлөх бүрэлдэхүүний нь 9000000-ээс-9999999 хүртэл, бусад татах хөдлөх бүрэлдэхүүний нь 0000001-ээс 8999999 хүртэл тоог агуулсан байна.

4.18 Хяналтын тоо

Хяналтын тоо нь татах хөдлөх бүрэлдэхүүний нэгжийн дугаарын хамгийн баруун талд оршиж зураасаар тусгаарлагдсан байх ба Олон улсын төмөр замын хамтын ажиллагааны O+913 аргачлалын дагуу тодорхойлж хэрэглэнэ. Энэхүү хяналтын тоо нь 12 оронтой дугаарлалттай татах хөдлөх бүрэлдэхүүний таних тэмдэг мөн 11 орон тоотой нийлж тоон дугаарыг үүсгэнэ.

Хяналтын орны тоог Олон улсын Төмөр замын хамтын ажиллагааны байгууллагаас баталсан O-913 аргачлалд заасан дагуу тодорхойлно. Иймээс хяналтын ороны тоо нь дараах байдлаар тодорхойлогдоно. Үүнд:

- Цувралын дугаарын тэгш байрлалыг (баруунаас тоолно) нэгээр үржүүлнэ;
- Цувралын дугаарын тэгш байрлалыг (баруунаас тоолно) хоёроор үржүүлнэ.
- Тэгш болон сондгой байрлалын үржвэрүүдийн нийлбэрийг олно.
- Гарсан нийлбэрийн нэгжийн эгнээг тооцож үзнэ.

-Нэгжийн эгнээг 10-аас хасч гарсан ялгавар нь хяналтын тоог тодорхойлно. Хэрэв нийлбэрийн нэгжийн орон тэгтэй тэнцүү бол хяналтын ороны тоо мөн тэгтэй тэнцүү байна.

жишээ:

Татах хөдлөх бүрэлдэхүүний 8R42047 ПКП , стандарт дугаар 92 51 00 42 03 7-

А) Татах хөдлөх бүрэлдэхүүний анхны дугаар: **9 2 5 1 0 0 4 2 0 3 7-9**

4-р хүснэгт - Татах хөдлөх бүрэлдэхүүний хяналтын тоог тодорхойлох аргачлал

Дугаарын тоо	9	2	5	1	0	0	4	2	0	3	7	Хяналтын
үржвэр	2	1	2	1	2	1	2	1	2	1	2	
Хариу	18	2	10	1	0	0	8	2	0	3	14	Нийлбэр:31 10-1=9

Тоон цувааны аравтын орон 1-тай тэнцүү байгаа хяналтын тоон аргачлал дагуу хяналтын тоо нь 9 болно. Үүнийг үндэслэн тухайн татах хөдлөх бүрэлдэхүүний нэгжийн дугаар 92 51 0042037-9 байна.

Б) Татах хөдлөх бүрэлдэхүүний анхны дугаар

9 1 8 8 0 0 0 1 3 2 3

2 1 2 1 2 1 2 1 2 =18+1+16+8+0+0+0+1+6+2+6

НИЙЛБЭР: 1+8+1+1+6+8+0+0+0+1+6+2+6=40

Тоон цувааны нэгжийн орон 0-тэй тэнцүү.Хяналтын оронтой тоо 0-тэй тэнцүү байгааг үндэслэн тухайн татах хөдлөх бүрэлдэхүүний нэгжийн дугаар 91 88 0001323–0 байна.

4.19

Хэрэв шаардлагатай бол тухайн улсад бүртгэгдсэн хөдлөх бүрэлдэхүүний дугаарын тооны өмнө “0” болон техникийн үзүүлэлтийг заах орны тоог тавьж, 4-6 оронтой тоон дугаарлалтыг бүрдүүлэн хэрэглэж болно.

4.20 Ашиглалтын үед татах хөдлөх бүрэлдэхүүн 2 секцитэй явах үед дугаарлалтыг секци тус бүр дээр тавих ба эхний секцийг “А”, арын секцийг “Б” гэж тодоор тэмдэглэсэн байна.

MNS 6630-3 : 2016

4.21 Татах хөдлөх бүрэлдэхүүнийг техникийн болон тээврийн баримт бичиг дээр 12 оронтой дугаарлалтаар бичиж тэмдэглэсэн байх ба татах хөдлөх бүрэлдэхүүн дээр дугаарыг байршуулахдаа сүүлийн 4-6 орон бүхий тоон дугаарлалтаар буюу зураг №1-т заасны дагуу байршуулна.

5 Татах хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтын ашиглалт

5.1 Ашиглалтын тэмдэг, тэмдэглэгээ нь Татах хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалт, түүний таних тэмдэг тэмдэглэгээ нь нэгдсэн системд болон суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч, хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгч нарын үйл ажиллагааг зохицуулахад зайлшгүй шаардлагатай.

5.3 Татах хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтыг ашиглах явцад төмөр замын тээврийн сүлжээнд давхардалт, зөрчил үүсэхгүй байх ба онцгой тохиолдолд засч залруулсан байна.

ЖИШЭЭ нь:

Төмөр замын эрх бүхий яамд байгууллагуудаар тогтоож өгсөн дүрэм, зааврыг хөндөөгүйгээр зөвхөн ЖИШЭЭ, үзүүлэн, таниулах үүднээс тайлбарлав.

ТЭМ2-1245 гэсэн бодит дугаар агуулсан зүтгүүр дээр дараах тэмдэглэгээг тавина:

-Хажуу ханан дээр болон машинчийн бүхээгний 2 цонхны дотор дугаарлалтын тэмдэг, тэмдэглэгээг том, тодоор бичнэ.—**89 31 01 01245-4**

ТЭМ2-1245 бодит дугаарлалтын тэмдэгээг зүтгүүрийн их биений урд болон хажуу талын ханан дээр том, тодоор бичнэ.

6 Татах хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтын үсгэн тэмдэглэгээ

6.1 Татах хөдлөх бүрэлдэхүүний их бие дээр бүртгэсэн улсын тэмдэглэгээ стандартын шаардлага дагуу тавина.

6.2 Татах хөдлөх бүрэлдэхүүнийг бүртгэсэн улсын тэмдэглэгээг 1949 оны конвенцийн 45/4/-р зүйлийг үндэслэн тоо болон үсгэн кодчиллоор тэмдэглэнэ.

6.3 Олон улсын Төмөр замын хамтын ажиллагааны байгууллагын гэшүүнээр бүртгэгдсэн улсын кодыг татах хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтын өмнө тавина. Дугаарлалтын тэмдэглэгээнд том болон жижиг үсэг ашиглаж болно.

6.4 Олон улсын Төмөр замын хамтын ажиллагааны байгууллагын төмөр замуудын татах хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгчийн тэмдэглэгээ нь нэгэн ижил буюу энэхүү стандартын дагуу давхардалгүй, зөв, ойлгомжтой бичсэн байх шаардлагатай.

6.5 Татах хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгчийн тэмдэглэгээ нь дээд тал нь 8, доод тал нь 2 тэмдэгтээс бүрдсэн, үсэг-тоон кодон бүтэцтэй, эхний хоёр тэмдэг нь том үсгээр бичигдсэн байх шаардлагатай.

MNS 6630-3 : 2016

6.6 Татах хөдлөх бүрэлдэхүүний дугаар, код, логог дараах зурагт заасны байршуулна.



УБТЗ ХНН-ийн эмблем



1-р зураг - Татах хөдлөх бүрэлдэхүүн дээр дугаар, тэмдэглэгээг бичиж байрлуулсан байдал

ЖИШЭЭ НЬ: 2ТЭ116УМ-026^а /026^б, 2ТЭ116УМ-илчит тэрэгний төрөл, 026^а-1-р секцийн дугаар, 026^а-2-р секцийн дугаар.

ТӨГСӨВ.

**А хавсралт
(норматив)**

Татах хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтын бичиглэлийн шрифт

А.1 Татах хөдлөх бүрэлдэхүүний бичиглэлтийн шрифт




А.1-р зураг - Бичиглэлтийн шрифт

А2. Татах хөдлөх бүрэлдэхүүний дээрх бичиглэлтийн үсэг болон тооны хэмжээсийг дараахь хүснэгтэнд үзүүлэв.

А.1-р хүснэгт - Бичиглэлтийн үсэг болон тооны хэмжээ


Шрифтын номер		1	2	3	4	5	6	7
Тоо болон үсэг	Өндөр Н /мм/	154	126	84	70	49	28	21
	Өргөн В /мм/	22	18	12	10	7	4	3

А3. Татах хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтын тооны шрифт




А.3-р зураг - Дугаарлалтын тооны дүрс, хэлбэр

А4. Татах хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтын тооны хэлбэр, хэмжээс




А.4 зураг - Дугаарлалтын тооны хэлбэр хэмжээс

хэмжээс.мм-ээр



хэмжээс.мм-ээр



А.4-р зураг - Дугаарлалтын тоо, үсэгний хэлбэр хэмжээс

А.5 Татах хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтын тоо, үсэгний хэмжээний ерөнхий шаардлага

Татах хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтын тэмдэг, тэмдэглэгээ тавих ерөнхий хэмжээ дараахь байдлаар бичигдэнэ:

- Тара (Вагоны өөрийн жин) –үгний үсэгний өндөр - 84 мм, өргөн – 40 мм, үсэг хоорондын зай 12 мм
- Тара (Татах хөдлөх бүрэлдэхүүний өөрийн жин)-ын ард бичигдэх тооны өндөр-126 мм, өргөн - 48 мм тоо хоорондын зай 12 мм
- Татах хөдлөх бүрэлдэхүүний эзэлхүүний тооны өндөр-84 мм, өргөн 48 мм, тоо хоорондын зай - 12 мм
- Татах хөдлөх бүрэлдэхүүний тонн, даац үгний үсэгний өндөр - 84 мм, өргөн – 48 мм, тоо хооронд - 12 мм
- Татах хөдлөх бүрэлдэхүүний засварын хугацааны үсэг, тооны бичиглэлийн өндөр - 70 мм, өргөн – 40 мм, үсэг хоорондын зай 10 мм

А.5 Татах хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтын тэмдэг, тэмдэглэгээнд тавих шаардлага

Татах хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтын тэмдэг, тэмдэглэгээг их биений хоёр хажуу хананд болон арал дээр тавина. Их бие буюу машинчийн бүхээгтэй хэсгийн эхний баганад түүнийг бүртгэсэн улсын лого, код байх ба Монгол Улсын төмөр

MNS 6630-3 : 2016

замын код-31, лого “сүлд”-г зэргийг тэмдэглэн бичсэн байх мөн 2 болон 3-р баганад өмчлөгчийн код, лого, дугаарыг тэмдэг, тэмдэглэгээ бичиглэлтийг хийсэн байна.

Татах хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтын системийг шинэчлэх, энэхүү стандартын дагуу шинээр дугаарлалтын бичилтийг хийх зэрэг үйл ажиллагааг үе шаттайгаар, мөн дунд болон их засварын хийсний дараа өөрчлөн бичиж болно. Стандартын дагуу дугаарлалт, тэмдэг тэмдэгээ, бичиглэлтийг хийсэн талаар техникийн паспортанд тэмдэглэж, эрх бүхий хүнээр баталгаажуулсан байх шаардлагатай.

В хавсралт
(норматив)

В1.-р хүснэгт - Зүтгүүрийн техникийн үзүүлэлт
8, 9, 10, 11 орны тооны утга

8-р орон Зориулалт	0	Чөлөөтэй
	1	Суудлын
	2	Ачааны
	3	Сэлгээний
	4	Үйлдвэрийн
	5	Тусгай зориулалтын
	6	Чөлөөтэй
	7	Чөлөөтэй
	8	Чөлөөтэй
	9	Чөлөөтэй
9-р орон ТХБ-ний секцийн тоо	0	Чөлөөтэй
	1	1 секцтэй
	2	2 секцтэй
	3	3 секцтэй
	4	3 секцтэй
	5	Чөлөөтэй
	6	Чөлөөтэй
	7	Чөлөөтэй
	8	Чөлөөтэй
	9	Чөлөөтэй
10-р орон Голын тоо	0	Чөлөөтэй
	1	1-2 голтой
	2	3-4 голтой
	3	5-6 голтой
	4	7-8 голтой
	5	9-10 голтой
	6	11-12 голтой
	7	13-14 голтой
	8	15-16 голтой
	9	17-18 голтой
11-р орон Голын даралт	0	Чөлөөтэй
	1	0-10тн
	2	11-15тн
	3	15-20тн
	4	21-22тн
	5	23-24тн
	6	25-26тн
	7	27-28тн
	8	29-30 тн
	9	31+тн